



СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ


Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ


2020 оны 7-р сар

МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс: 16,448 +0.2% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



МХБ-А индекс: 7,936 -0.7%, МХБ-В индекс: 7,351 -0.2% (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)



Олон улсын индексүүд

Индекс	2019.06.30	2020.07.31	Өөрчлөлт, %
DJIA (US)	25,812	26,428	2.3%
S&P 500 (US)	3,100	3,271.12	5.5%
Nikkei 225 (JP)	22,288	21,710	-2.6%
Hang Seng (HK)	24,427	24,595	0.6%
DAX 30 (DE)	12,310	12,313	0.02%
SMI (CH)	10,045	10,005	-0.4%

Валютын ханш

Валют	2019.06.30	2020.07.31	Өөрчлөлт, %
USD	2,823.89	2,844.70	0.7%
EUR	3,169.39	3,372.39	6.4%
JPY	26.21	27.18	3.7%
RUB	40.07	38.59	-3.6%
CNY	399.52	407.72	2.0%
KRW	2.35	2.35	0.0%

Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	4.7	-63.2%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,538.9	+1.5%
Бүртгэлтэй компани	199	+1
Арилжаалагдсан хувьцаа	66	-9
Арилжаалагдсан өдөр	20	+1

Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.06.30	2020.07.31	Өөрчлөлт, %
UYN	450.00	680.00	+51%
ERDN	610.00	896.20	+46%
SOH	38.00	55.00	+44%
UBH	17,000.00	20,500.00	+20%
TUS	600.00	750.00	+20%

Зах зээлийн мэдээлэл

ҮЦТХТ-д нээгдсэн дансны мэдээлэл

ҮЦТХТ-д 7-р сард нийт 3,504 данс нээгдсэнээс 1,918 данс шинээр, 1,586 данс холболтоор нээгдсэн ба шинээр нээгдсэн дансдын бүтцийг харвал 1,909 дотоодын иргэн, 2 гадаадын иргэн, 7 дотоодын аж ахуйн нэгжийн данс тус тус нээгдсэн байна.

Үнэт цаасны бүртгэлийн ангилал шинэчлэгдлээ

МХБ нь үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу хувьцаат компаниудын ангиллыг тогтоодог. МХБ-д бүртгэлтэй компаниудаас үйл ажиллагаа, ашиг орлого, арилжааны идэвх, компанийн засаглалаараа тэргүүлэгч компанийг оруулдаг 1-р ангилалд 15 хувьцаат компани байсан дээр 2020 онд нэмж Түмэн шувуут ХК, Монос хүнс ХК, Хөвсгөл алтандуулга ХК ангилал ахиж орсноор нийт 18 хувьцаат компани тус ангилалд бүртгэлтэй байна. Мөн Инвескор ББСБ ХК, Тээвэр-дархан ХК, Монгол даатгал ХК, Монгол шевро ХК, Нэхээсгүй эдлэл ХК зэрэг 5 компани ангилал ахин, 2-р ангилалд орсон бол Мерекс ХК, Нако түлш ХК, Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК, Хөх ган ХК ангилал буурч 3-р ангилал руу шилжсэн байна.

1-р ангилалд багтаж буй компаниуд

№	Симбол	Компаниуд
1	APU	Апу ХК
2	AIC	Ард даатгал ХК
3	BNG	Баянгол зочид буудал ХК
4	LEND	Би ди сек ХК
5	GOV	Говь ХК
6	NEH	Дархан нэхий ХК
7	LEND	ЛэндМН ББСБ ХК
8	MNDL	Мандал даатгал ХК
9	MMX	Махимпекс ХК
10	MIK	Мик холдинг ХК
11	MNP	Монгол шуудан ХК
12	SUU	Сүү ХК
13	TTL	Тавантолгой ХК
14	TCK	Талх чихэр ХК
15	MFC	Монос хүнс ХК
16	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК
17	TUM	Түмэн шувуут ХК
18	BODI	Бодь даатгал ХК

Монгол даатгал ХК-ийн симбол өөрчлөгдлөө

Монгол даатгал ХК-ийн зүгээс арилжааны CHE симболыг MDIC болгон өөрчлөх хүсэлтийг гаргасан тул СЗХ-ноос зөвшөөрч, үүнтэй холбоотой тухайн үнэт цаасны арилжааг 2020 оны 7-р сарын 7-ны өдрөөс эхлэн түр зогсоосон байсныг 2020 оны 7-р сарын 29-ний өдрөөс эхлэн сэргээв.

Дархан нэхий ХК-ийн арилжааг зогсоолоо

Дархан нэхий ХК-ийн 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаагаа 1000 хуваах шийдвэрийг гаргасан. СЗХ-ноос тухайн шийдвэрийг хэлэлцэн зөвшөөрсөн тул хувьцааны арилжааг 2020 оны 7-р сарын 9-нөөс эхлэн ҮЦТХТ-д хувьцааны бүртгэл бүрэн хийгдэж дуусах хүртэл түр зогсоосон байна.

Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн ХК нэмэлт санхүүжилт босголоо

МХБ-д бүртгэлтэй Эрдэнэ ресурс девелопмент ХК нь хаалттай хүрээнд нэмж 20 сая канад долларын хөрөнгө оруулалтыг

Хамгийн их бууралттай

Хувьцаа	2020.06.30	2020.07.31	Өөрчлөлт, %
SHG	1,360.00	884.67	-34%
VIK	24.00	17.90	-25%
MBG	6,000.00	5,000.00	-16%
GTJ	694.00	590.00	-15%
BTG	25,000.00	21,260.00	-15%

Хамгийн их арилжигдсан

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх %
INV	1,157,282	2,491.1	52.9%
MMX	190,829	462.0	9.8%
BDS	460,041	455.4	9.6%
BNG	6,059	181.4	3.8%
ERDN	215,683	162.0	3.4%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их өссөн, тэрбум төгрөгөөр

Компани	2020.07.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
UYN	1.1	0.5	+51.1%
ERDN	2.4	1.1	+46.9%
SOH	0.5	0.2	+44.7%
UBH	6.8	1.4	+20.5%
TUS	2.6	0.5	+20.0%

Зах зээлийн үнэлгээ хамгийн их буурсан, сая төгрөгөөр

Компани	2020.07.31	Өөрчлөлт	Өөрчлөлт, %
SHG	13,831.5	4,834.2	-34.9%
VIK	23,907.8	6,076.4	-25.4%
MBG	2,401.2	400.2	-16.6%
GTJ	396.1	59.3	-14.9%
BTG	6,318.2	944.7	-14.9%

татан төвлөрүүлсэн байна. Нийт босгосон хөрөнгө оруулалтын 75% буюу 15 сая канад долларын хувьцааг ноён Эрик Спротт авчээ. Эрик Спротт нь өөрийн хөрөнгийн 90 орчим хувийг алтанд хөрөнгө оруулалт хийсэн алтаны магнат бизнесмен юм. Тухайн санхүүжилтээр анхан шатны бүтээн байгуулалт, өндөр агууламж бүхий алтны нөөцийг тэлэх хайгуулын ажлыг санхүүжүүлнэ хэмээн компанийн зүгээс мэдэгджээ.

Бодь даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

2020 онд МХБ дээр хувьцаагаа анх удаа олон нийтэд амжилттай санал болгосон Бодь даатгал ХК нь хувьцаат компани болсноос хойшхи анхны Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар болсон байна.

Хурлын тов: 2020 оны 9-р сарын 9-ний өдрийн 11:00 цагт

Хуралдах газар: УБ хот, Novotel зочид буудлын 4 давхрын хурлын танхимд

Бүртгэлийн өдөр: 2020 оны 8-р сарын 17-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

- 2020 оны хагас жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг тайлагнах;
- 2020 оны хоёрдугаар хагасын бизнес төлөвлөлтийг танилцуулах
- Компанийн “Дүрэм”-ийн төслийг батлах;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв батлах зэрэг асуудлуудыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэн шийдвэрлэх юм байна.

2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлагнал

Энэ сард МХБ-д бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн санхүүгийн тайлангаа танилцууллаа. Санхүүгийн тайлангаа ирүүлсэн хувьцаат компанийн тайлангуудаас харахад 2020 оны эхний хагас жилд компаниудын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд COVID-2019 гэх дэлхий нийтийг хамарсан цар тахал нөлөөлсөн нь харагдаж байна. Жишээлбэл, нүүрсний экспорт эхний саруудад саатсан ба олон улсын ачаа тээвэр гацсан, хил гаалиар нэвтрэлт удааширсан зэрэг нь Таван толгой ХК болон Говь ХК-ийн борлуулалтад шууд нөлөөлжээ. Тавантолгой ХК нь өмнөх оны мөн үед 19 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол энэ оны хагас жилээр 3.9 тэрбум төгрөг болж буурсан, харин Говь ХК-ийн хувьд 21 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийтлэг асуудал нь бараа материал, түүхий эд татан авах үйл ажиллагаанд саатал үүсч, цаг хугацаа их зарцуулж, тээврийн зардал өссөн явдал бөгөөд энэ нь бараа бүтээгдэхүүний өртөгт нөлөөлж буй аж. Нөгөөтэйгүүр, ашиг борлуулалт нь нэмэгдсэн салбарууд байна. Тухайлбал, хүнсний салбар тэр дундаа сүү сүүн бүтээгдэхүүний борлуулалт өсчээ. Цэвэр ашгийн дүнг харвал АПУ ХК 41.1 тэрбум төгрөг, энэ нь өмнөх оны мөн үеэс 31.9 (346.7%) тэрбум төгрөгөөр, Инвекор ББСБ ХК 6.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.1 (52.5%) тэрбум төгрөгөөр, УБ-БҮК ХК 5.1 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 6.3 (525%) тэрбум төгрөгөөр, Монгол шуудан ХК 3 тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 2.7 (900%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна /дараагийн хуудсанд буй хүснэгтийг харна уу/.

Шинээр 2019 онд IPO хийсэн компаниуд болох Монос хүнс ХК 399 сая төгрөг, Түмэн шувуут ХК 2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Монос хүнс ХК-ийн хувьд 2020 оны эхний улиралд шинэ хүнсний үйлдвэрээ ашиглалтанд оруулсан хэдий ч цар тахлын улмаас бүрэн чадлаар ажиллаагүй, шинээр баригдсан үйлдвэрийн хувьд үйлдвэрлэлийн зардал өндөртэй байгаа гэх шалтгаанаас үүдэн цэвэр ашиг нь хүлээлтэнд хараахан хүрээгүй байна. Түмэн шувуут ХК-ийн хувьд татан төвлөрүүлсэн хөрөнгөөрөө төлөвлөсөн бүх бүтээн байгуулалтыг хийсэн, компанийн ашигт ажиллагаа болон борлуулалт тасралтгүй өсч буй, цаашид ч өсөх хүлээлттэй байгаа, засаглал сайтай компанид тооцогддог.

2020 оны эхний хагас жилийн үзүүлэлтүүдийг ерөнхийд нь харахад хоёрдугаар хагас жилийн төсөөлөл тийм ч таатай биш байна. Учир нь цар тахлын нөлөөлөл манайд төдийгүй дэлхий даяар улам гүнзгийрэх магадлал их байна. Хувьцааны голлох харьцаануудыг тооцоолон гаргасныг манай <http://www.standardinvestment.mn/> сайтын “Мэдлэгийн санд” цэсний “Судалгаа” булангаас үзнэ үү. Үнэ ашгийн харьцааны үзүүлэлтээр дээгүүр орж буй компаниудын ихэнх нь МХБ-ийн 1-р самбарын компаниуд байна. Говь ХК болон Баянгол зочид буудал ХК гэх мэт зарим компанийн ашгийн үзүүлэлт энэ хагас жилд буурснаар доошилсон байна.

2020 оны эхний хагас жилийн байдлаар дорх хувьцаат компаниуд ашигтай ажилласан байна. Компаниудыг цэвэр ашгийн хэмжээгээр дэс дарааллуулан байршуулав.

№	Компаниуд	Нийт хөрөнгө, мян. төгрөг	Нийт өр төлбөр, мян. төгрөг	Эздийн өмч, мян. төгрөг	Цэвэр ашиг, мян. төгрөг
1	Апу	581,216,633.4	109,052,178.3	472,164,455.1	41,168,156.4
2	Инвескор	97,413,708.1	50,920,422.0	46,493,286.1	6,104,592.0
3	Уб-бүк	111,673,220.9	72,961,183.4	38,712,037.5	5,150,011.2
4	Тавантолгой	105,151,065.5	54,948,271.7	50,202,793.8	3,912,236.5
5	Монгол шуудан	29,663,302.9	6,842,655.0	22,820,647.9	3,002,909.0
6	Лэндмн ББСБ	47,096,268.8	28,271,502.5	18,824,766.2	2,820,287.7
7	Мандал даатгал	51,911,893.5	31,526,488.9	20,385,404.6	2,298,901.8
8	Сүү	66,703,609.3	39,257,971.3	27,445,638.0	2,078,257.1
9	Түмэн шувуут	34,592,360.2	9,613,760.3	24,978,599.9	2,022,207.1
10	Хөвсгөл алтандуулга	16,083,788.2	4,911,601.2	11,172,187.0	863,427.0
11	Талх чихэр	72,809,687.2	22,492,376.1	50,317,311.1	818,179.3
12	Ард санхүүгийн нэгдэл	73,307,564.3	22,483,235.8	50,824,328.5	777,161.2
13	Бодь даатгал	27,160,837.8	14,813,451.0	12,347,386.8	765,219.6
14	Ард кредит ББСБ	24,554,343.0	14,405,092.3	10,149,250.7	548,821.8
15	Гермес центр	8,630,133.2	245,606.1	8,384,527.1	530,227.0
16	Монос хүнс	21,584,336.8	5,737,955.2	15,846,381.6	399,919.2
17	Дархан нэхий	63,141,995.9	18,828,178.3	44,313,817.6	276,067.7
18	Материалимпекс	46,269,140.9	21,225,858.7	25,043,282.2	235,028.8
19	Улаанбаатар хивс	9,135,319.2	2,393,246.1	6,742,073.1	118,505.1
20	Тахь-ко	15,483,831.3	94,188.5	15,389,642.8	117,955.6
21	Монгол даатгал	37,648,986.5	23,889,093.7	13,759,892.8	116,902.2
22	Талын гал	2,654,960.6	1,091,548.1	1,563,412.5	108,624.6
23	Тандем инвест	2,354,576.6	10,459.3	2,344,117.3	85,506.2
24	Атар өргөө	13,143,448.3	754,792.6	12,388,655.7	76,357.0
25	Ариг гал	61,842,933.0	51,882,209.9	9,960,723.1	54,193.4
26	Улсын их дэлгүүр	8,039,794.5	9,150,581.7	-1,110,787.2	37,357.5
27	Э-транс ложистикс	5,070,972.4	238,497.8	4,832,474.6	37,218.7
28	Айтүүлс	3,435,939.9	200,788.2	3,235,151.7	35,569.6
29	Могойн гол	5,334,089.5	2,180,432.2	3,153,657.3	21,830.9
30	Монгол базальт	29,350,979.4	2,426,163.9	26,924,815.5	19,384.8
31	Дорнод худалдаа	2,422,257.7	743,015.6	1,679,242.1	17,645.9
32	Увс хүнс	3,768,076.5	1,767,959.1	2,000,117.4	16,631.0
33	Газар сүлжмэл	3,529,194.7	1,181,181.8	2,348,012.9	15,005.3
34	Завхан баялаг	1,734,307.0	1,392,401.8	341,905.2	10,677.8
35	Нэхээсгүй эдлэл	6,725,995.1	5,150,486.5	1,575,508.6	6,768.4
36	Хасу мандал	1,233,418.6	0.0	1,233,418.6	1,433.6
37	Тулпар	27,917.8	640.0	27,277.8	270.0
38	Дорнод авто зам	379,017.4	68,843.8	310,173.6	30.8

2020 оны эхний хагас жилийн байдлаар дорх хувьцаат компаниуд алдагдалтай ажилласан байна. Компаниудыг алдагдлын хэмжээгээр нь дэс дарааллуулан байршуулав.

№	Компаниуд	Нийт хөрөнгө, мян. төгрөг	Нийт өр төлбөр, мян. төгрөг	Эздийн өмч, мян. төгрөг	Цэвэр ашиг, мян. төгрөг
1	Бөөний худалдаа	78,195.5	259,069.1	-180,873.5	- 251.4
2	Ачит алкабы	86,076.7	900.1	85,176.6	- 500.0
3	Монгол дизель	2,443,959.6	73,937.9	2,370,021.7	- 500.0
4	Сэлэнгэ дулаанхаан	5,060.0	5,210.1	-150.1	- 1,217.4
5	Ган хэрлэн	2,128,326.5	102,969.7	2,025,356.8	- 4,576.1
6	Түшиг уул	2,011,380.5	363,510.0	1,647,870.5	- 4,607.1
7	Глобал лайф технологи	6,987.2	8,000.0	-1,012.8	- 5,784.2
8	Монгол савхи	1,738,958.0	212,743.7	1,526,214.3	- 6,241.7
9	Монгол нэхмэл	3,472,574.2	3,338,687.4	133,886.8	- 8,468.2
10	Дархан зочид буудал	1,197,823.7	536,924.0	660,899.7	- 19,803.8
11	Хөх ган	31,456,101.6	14,552,703.5	16,903,398.1	- 19,878.1
12	Хөсөг трейд	919,158.7	36,929.5	882,229.2	- 20,609.6
13	Жуулчин говь	352,492.1	313,351.6	39,140.5	- 23,230.5
14	Хот девелопмент	15,262.1	836,751.6	-821,489.5	- 27,696.2
15	Хөвсгөл усан зам	172,155.2	3,686,995.9	-3,514,840.7	- 31,709.1
16	Шинэст	2,157,149.3	627,603.6	1,529,545.7	- 64,703.7
17	Оллоо	1,212,868.7	38,584.9	1,174,283.8	- 73,339.9
18	Мерекс	7,506,108.3	2,524,512.8	4,981,595.5	- 89,098.6
19	Монинжбар	4,785,097.9	3,158,015.2	1,627,082.7	- 95,138.3
20	Хай би ойл	4,867,627.4	440,271.6	4,427,355.8	- 115,002.3
21	Техник импорт	59,014,161.1	46,655,436.0	12,358,725.1	- 136,889.5
22	Монголын цахилгаан холбоо	42,366,929.5	7,948,328.0	34,418,601.5	- 142,546.3
23	Ганхийц	8,120,827.0	7,751,734.2	369,092.8	- 182,132.4
24	Баянтээг	8,065,659.4	804,213.3	7,261,446.1	- 183,861.5
25	Махимпекс	11,904,455.4	8,855,070.0	3,049,385.4	- 293,309.9
26	Баянгол зочид буудал	32,231,173.1	465,458.5	31,765,714.6	- 394,874.3
27	Женко тур бюро	9,908,250.2	1,187,024.2	8,721,226.0	- 560,154.0
28	Мон-ит булигаар	15,305,498.1	7,945,650.1	7,359,848.0	- 566,040.3
29	Адуунчулуун	8,444,633.1	641,593.8	7,803,039.3	- 614,188.2
30	Би ди сек	24,380,270.2	7,798,464.6	16,581,805.6	- 627,986.0
31	Ремикон	20,169,103.5	12,911,925.1	7,257,178.4	- 837,032.8
32	Евроазиа капитал холдинг	1,168,794.4	1,071,967.0	96,827.4	- 1,088,639.3
33	Фронттиер лэнд групп	11,110,105.1	475,700.8	10,634,404.3	- 1,945,577.4
34	Бэрх уул	14,196,334.5	49,838,968.1	-35,642,633.6	- 2,690,014.5
35	Шарын гол	80,212,418.7	62,443,457.4	17,768,961.3	- 3,575,018.7
36	Багануур	245,418,430.3	178,414,417.4	67,004,012.9	- 5,703,845.2
37	Мик холдинг	4,224,486,404.7	3,967,729,940.1	256,756,464.6	- 5,887,363.0
38	Говь	374,276,576.0	316,569,837.0	57,706,736.0	- 21,396,965.0

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ



МӨНГӨ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 7-р сарын эцэст 21.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.1 (5.3%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 1.7 (56.7%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 243.2 (2.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2020 оны 7-р сарын эцэст 926.3 тэрбум болж, өмнөх сараас 61.0 (6.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 8.7 (0.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, жилийн эцэст, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019.07	2020.07*
Мөнгө M2	20,289.9	21,355.5
Бага мөнгө M1	3,783.2	3,458.1
Төгрөгийн харилцах	3,139.8	2,798.1
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	643.5	660.0
Бараг мөнгө	16,506.5	17,897.3
Төгрөгийн хадгаламж	10,895.6	11,138.8
Валютын хадгаламж	2,926.1	4,584.3
Валютын харилцах	2,684.9	2,174.2
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	935.0	926.3

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 7-р сарын эцэст 17.3 их наяд төгрөг болж, өмнөх сараас 40.4 (0.2%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 945.1 (5.2%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2020 оны 7-р сарын эцэст 1.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 129.5 (12.9%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 257.9 (29.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2020 оны 7-р сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 25.0 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 10.9 (0.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 43. Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төгрөг



УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн нийт хэмжээ 2020 оны эхний 7-р сарын урьдчилсан гүйцэтгэлээр 5.3 их наяд төгрөг, үүнээс нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж нь 4.9 их наяд төгрөг болж нийт орлогын 93.1 хувийг эзэлж байна. Нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 7.4 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2.5 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа.

— Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого
— Нэгдсэн төсвийн зарлага
— Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл



Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2020 оны энхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 722.6 сая ам. долларын алдагдалтай гарч, алдагдалтай гарахад үйлчилгээний худалдааны тэнцэл 647.6 сая ам. Доллар, анхдагч орлогын данс 429.7 сая ам. долларын алдагтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.


Зураг 20. Урсгал данс, сая америк доллароор, сараар



ГАДААД ХУДАЛДАА

Монгол Улс 2020 оны эхний 7-р сард нийт 135 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6.7 тэрбум ам. доллар, үүнээс экспорт 3.8 тэрбум ам. доллар, импорт 2.9 тэрбум ам. долларт хүрлээ. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.3 (16.1%) тэрбум ам. доллар, үүнээс экспорт 728.8 (17.1%) тэрбум ам. доллароор, импорт 14.2 (3.0%) сая ам доллараар тус тус өссөн байна.

Зураг 51. Экспорт, импорт, тэнцэл, сараар, сая америк доллар




Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2019 оны 7-р сард 1.1 тэрбум ам. долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний 7-р сард өмнөх оны мөн үеэс 217.7 сая ам. доллароор буурч, 846.6 сая ам. долларын ашигтай байна.



ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7-р сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.5 хувь, өмнөх оны эцсээс 3.3 хувь, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар өссөн байна.

Зураг 55. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх сараас 0.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.3 хувиар (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0.1 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.2 хувь, тээврийн бүлгийн үнэ 0.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Холбоо барих хаяг

Стандарт инвестмент ҮЦК
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо
АвтоХаб төв, 1-2 давхар

Утас: 70114433
info@standardinvestment.mn
www.standardinvestment.mn
https://dbx.standardinvestment.mn/

Шуудангийн хаяг:

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487
УБ - 15160

iOS



Android



Web



Тодруулга болон мэдэгдэл

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.